

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД, САНГИЙН САЙД,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД,
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/05, А/21, А/19, 27


Улаанбаатар хот


Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2023 оны “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 06 дугаар тогтоолын 2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолын 2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 699 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаанд тавих хяналтын журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар болон Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргад тус тус даалгасугай.





Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, Уулзуурхай, хунд
үйлдвэрийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны
даргын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн
А/ОС, А/АТ, А/НЗ, 27 дугаар хамтарсан тушаалын хавсралт

ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ НЭЭЛТТЭЙ ЦАХИМ АРИЛЖААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.“Эрдэнэс Тавантолгой” ХК болон хүсэлт гаргасан Гапшунсухайт боомт дахь “Чингэлэгт тээврийн терминал”-аар нүүрс экспортлогч аж ахуйн нэгжийн экспортын нүүрсний арилжааг цахим системээр дамжуулан хууль тогтоомж, холбогдох журамд заасны дагуу зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавихтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

Хоёр.Хяналт тавих этгээд, түүний бүрэн эрх

2.1.Нүүрсний нээлттэй цахим арилжааг цахим системээр дамжуулан хууль тогтоомж, холбогдох журамд заасны дагуу зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ хэрэгжүүлнэ.

2.2.Хороо нь энэ журмын 2.1-д заасан чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.2.1.хууль тогтоомж, арилжааг зохион байгуулахтай холбогдох журмыг биелүүлж байгаа эсэхийг тогтоох зорилгоор зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх;

2.2.2.хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг арилжааг зохион байгуулагч, арилжаанд оролцогчдоос үнэ төлбөргүй гаргуулан авах;

2.2.3.хяналт шалгалтын дүгнэлт, эсхүл арилжааг зохион байгуулахтай холбоотойгоор илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулах, шаардлагатай тохиолдолд арилжааг зохион байгуулах хугацааг хойшлуулах;

2.2.4.арилжааг зохион байгуулахаас өмнө аливаа этгээдээс ирүүлсэн мэдээлэл, нотлох баримтад дурдсан арилжаа зохион байгуулагч, худалдагч, худалдан авагч, итгэмжлэгдсэн лаборатори зэргийн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол харьяаллын дагуу эрх бүхий төрийн байгууллагад шалгуулахаар шилжүүлж, тухайн арилжааг зохион байгуулах хугацааг хойшлуулах;

2.2.5.хууль тогтоомж, арилжааг зохион байгуулахтай холбогдох журмыг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй гэж үзсэн тохиолдолд харьяаллын дагуу эрх бүхий төрийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх;

2.2.6.арилжаатай холбоотой худалдагч, худалдан авагч талаас ирүүлсэн гомдлыг шийдвэрлэх;

2.2.7.шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийг оролцуулсан шинжээчдийн хэсгийг томилж, хяналт шалгалтыг хийх.

2.3.Хороо энэ журмын 2.2.1-д заасан хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг хагас жил тутамд, төлөвлөгөөт бус шалгалтыг шаардлагатай гэж үзсэн тухай бүр хийнэ.

Гурав.Бусад

3.1.Арилжааг зохион байгуулагч нь арилжаалсан нүүрсний нэр, төрөл, үнэ, хэмжээ, хугацаа, төлбөр тооцоо, арилжаанд оролцогч болон бусад холбогдох мэдээллийг арилжааг зохион байгуулж, хэлцэл бүрэн хийгдсэн өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

3.2.Арилжааг зохион байгуулагч нь арилжааны нэгдсэн тайланг улирал бүр дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

3.3.Хороо шаардлагатай тохиолдолд арилжааг зохион байгуулагчаас ирүүлсэн мэдээ, тайланд нэмэлт тодруулга, тайлбарыг холбогдох нотлох баримтын хамт шаардаж болно.

3.4.Энэ журмын 2.2.6-д заасан асуудлаар гаргасан Хорооны шийдвэрийг худалдагч, худалдан авагч тал эс зөвшөөрвөл маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй.

3.5.Хороо нь энэ журамд заасны дагуу хийсэн хяналт шалгалтын тайланг тухай бүр Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлнэ.

---oOo---